



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2018 он, 2019 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчин үйлдвэрийн газрын 2018, 2019 онуудад эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлуулаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2 дахь хэсэгт заасныг зөрчин 107.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэгт заасныг зөрчин анхан шатны баримтын бүрдэл дутуу 40.43 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж санхүүгийн тайланд бүртгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 4.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй худалдан авсан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, 2018 оны 129 дүгээр тогтоолыг зөрчин 40.0 сая төгрөг бүхий 2 ажил шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 279 дүгээр тогтоолоор 166.14 сая төгрөгийн балансын үнэтэй тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж өгсөн боловч үндсэн хөрөнгөд бүртгэж аваагүй зэрэг нийт 368.87 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ НЬ:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Б.Баттулгад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дэх зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 5 дахь хэсэгт заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах;

2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу орон тооны мэргэшсэн нягтлан бодогчийг томилж, ажиллуулах;

2.5. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэхийг таслан зогсоох;

2.6. Үйлдвэрийн газрын дотоод хяналтыг зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

2.7. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөн ажиллах, анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгахгүй байх;

2.8. Ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын чиг үүрэг, хууль тогтоомжийн дагуу боловсруулах, тухайн албан тушаалын шаардлагад нийцсэн ажилтныг сонгон шалгаруулж ажиллуулах;

2.9. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам боловсруулж, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.10. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, байгууллагын онцлогт нийцүүлэн тогтоож, элэгдлийг бүрэн, оновчтой тооцох;

2.11. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.12. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, шийдвэр, тушаалын хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнаж байх;

2.13. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах, биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

3.1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, захиралтай контрактыг байгуулж ажиллах;

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Ц. ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05 ны өдрийн
239-р тогтоолын хавсралт

“Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	2018, 2019 онуудад эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлуулаагүй, захиралтай контракт байгуулаагүй	Захирал	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 90 дүгээр тогтоол, 2019 оны 260 дугаар ажиллах.
2	Үргүй зардал гаргасан	Захирал, нягтлан бодогч	107.0	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т заасан “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” заалтуудыг мөрдөн ажиллах.
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу (Жич: 2018.11.20 хүртэлх кассын баримт байсан учир бодит мөнгөн дүн гаргах боломжгүй байсан)	Захирал, нягтлан бодогч	2018 онд ...	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” мөрдөн ажиллах.
			2019 онд 40.43	
4	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	Захирал, нягтлан бодогч	4.1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг мөрдөн ажиллах.
5	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	Захирал, нягтлан бодогч	40.0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Засгийн газрын 2013 оны 68, 2018 оны

				129 дүгээр тогтоолыг тус тус мөрдөн ажиллах.
6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 221 дүгээр тогтоолоор захирал Б.Пүрэвжавыг чөлөөлөн захирлын албан үүргийг маркетинг хариуцсан ажилтан Д.Бадрахад түр хариуцуулж санхүүгийн баримт (зөвхөн цалингийн) нэгдүгээр гарын үсэг зурах эрх олгосон боловч 3 ажилтан шинээр ажилд томилсон тушаал гаргаж, цалин олгосон	Захирал, нягтлан бодогч	АЖХТ ТӨААТҮГ-ын захирлын 2019 оны Б/7 тушаал Иргэн Б.Бүжинлхам 4.6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 221 дүгээр тогтоолоор олгосон эрх хэмжээг хэтрүүлж, иргэнтэй хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж цалин хөлс олгосон тул цалингийн зардлыг захирлын албан үүргийг түр гүйцэтгэж байсан Д.Бадрахад гаргуулан байгууллагын дансанд төвлөрүүлэх, гарсан шийдвэрийг хүчингүй болгох.
			АЖХТ ТӨААТҮГ-ын захирлын 2019 оны Б/5 тушаал Иргэн С.Сэргэлэнтөр 3.0	
			АЖХТ ТӨААТҮГ-ын захирлын 2019 оны Б/6 тушаал Иргэн М.Дархижав 3.6	
			Нийт 11.2	
7	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 279 дүгээр тогтоолоор “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн нэгжээс Тоёота Ландкрузер 200 маркийн тээврийн хэрэгслийг “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т шилжүүлсэн боловч үндсэн хөрөнгөд бүртгэж авалгүй, 2019 онд “Өвөрхангай АЗЗА” ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн.	Хуучин удирдлага	166.14	Цаашид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан эд хөрөнгөтэй холбоотой тогтоолын биелэлтийг тухай бүр хангаж ажиллах.
	Нийт дүн		368.87	